

**КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН
ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн: Ц.Туваан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын нутаг дэвсгэрт кадастр эрхлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах, кадастрын нэгдсэн тогтолцоог бий болгох, кадастрын үйл ажиллагааг тодорхой болгох, дундын мэдээллийн сангаар дамжуулан газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг эд хөрөнгийн Улсын бүртгэлд бүртгэхэд нэгж талбарын цахим хувийн иж бүрдэл, шийдвэрлэх хугацаа болон харилцан мэдээлэл солилцох, дугаар олгох үйл ажиллагааг зохицуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхээр уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар кадастрын мэдээллийн нэгдсэн сантай болох, иргэдийн газрын эдийн засгийн өгөөж, үнэ цэнийн ойлголт үнэлэмжийг нэмэгдүүлэн, газрын зах зээлийн үнэд тулгуурлан төлбөр, татварын хэмжээг бодит байдалд нийцүүлэн тогтоох, цахим бүртгэлийн үйлчилгээг кадастрт нэвтрүүлэх, нэгдсэн бүртгэлтэй болсноор улсын хэмжээний статистик тоо мэдээ бодитой, үнэн зөв гарч, газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг газрын нэгж талбарт суурилсан кадастрын зургийг үндэслэн бүртгэдэг болсноор давхардал, хийдэл гарахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан орон нутагт кадастрын зөрчил, маргаан ихээр гардаг, үүний нөхцөл, шалтгааныг тодорхойлж, хуулийн төсөлд зохицуулалтыг тодорхой тусгасан эсэх, кадастрын зураглал хийдэг компани, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд салбарын яам, холбогдох байгууллагын тавих хяналтын тогтолцоо хэрхэн хэрэгжиж байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.САРАНЧИМЭГ